124

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.11.20 № 36

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Ц.ТУВААН ТАНАА

Хуулийн биелэлттэй холбоотой
мэдээлэл ирүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлаас 2022 онд Уул Уурхайн Бүтээгдэхүүний Биржийн тухай хуулийг баталсан бөгөөд хэрэгжиж эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Тус хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор хууль хэрэгжсэнээс хойших зарим статистик мэдээллийг гаргуулж авах шаардлагатай боллоо.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Монгол Улсаас 2023-2024 онд нийт хичнээн тонн нүүрсийг биржээр арилжаалсан талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.Монгол Улсын хилээр арилжаалсан нүүрсний экспортын хэмжээ болон холбогдох бусад статистик мэдээллийг 2023-2024 оны байдлаар дэлгэрэнгүйгээр, тухайлбал Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалагдсан нүүрсний тоо хэмжээ, урт болон дунд хугацааны урьдчилгаат гэрээгээр арилжаалагдсан нүүрсний тоо хэмжээ /офтейк гэрээгээр/-г тус тус ирүүлэх.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН Х.ГАНХУЯГ

2024000056